

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2025 оны 09 дүгээр сарын 17-ны өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-4

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 5-28

1.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 07 дугаар дүгнэлт /Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн холбогдох заалт, 14.10 дугаар зүйлийн 11, 12 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай/ 6-14

2.““Алт-3” аяныг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2025 оны 85 дугаар тогтоолд хэсэгчлэн тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хориг 14-28

**Хууль зүйн байнгын хорооны
9 дүгээр сарын 17-ны өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 16 цаг 50 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Н.Алтанхуяг, Х.Баттулга, С.Одонтуяа, Д.Пүрэвдаваа, У.Отгонбаяр, П.Сайнзориг, Х.Тэмүүжин, Н.Учрал.

Нэг.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 07 дугаар дүгнэлт /Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн холбогдох заалт, 14.10 дугаар зүйлийн 11, 12 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, мөн албаны зөвлөх Д.Нямбаяр, референт Б.Баярсайхан, Хүний эрхийн дэд хороо хариуцсан референт Л.Хурцбилэг нар байлцав.

Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 07 дугаар дүгнэлтийг Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар танилцуулав.

Дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Алтангэрэл, Х.Баасанжаргал, Д.Цогтбаатар нар үг хэлэв.

Д.Цогтбаатар: 1.“Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.10 дугаар зүйлийн 11 дэх хэсэгт “Эрүүгийн хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх явцад прокурор, оролцогчийн гаргасан саналыг харгалзан шүүх эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтод нийцүүлэн шүүгдэгчид цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авч болно.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалтын “халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч ... баривчлах, хорих, ... эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. Баривчилсан шалтгаан, үндэслэлийг баривчлагдсан хүн, түүний гэр бүлийнхэн, өмгөөлөгчид нь хуульд заасан хугацаанд мэдэгдэнэ. ...” гэж заасныг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 4

Бүгд: 15

73.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Д.Цогтбаатар: 2.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.10 дугаар зүйлийн 11 дэх хэсэгт “Эрүүгийн хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх явцад прокурор, оролцогчийн гаргасан саналыг харгалзан шүүх эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтод нийцүүлэн шүүгдэгчийг цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авч болно.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад “... шударга шүүхээр шүүлгэх ... эрхтэй. ...” гэж заасныг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 4

Бүгд: 15

73.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Д.Цогтбаатар: 3.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.10 дугаар зүйлийн 11 дэх хэсэгт “Эрүүгийн хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх явцад прокурор оролцогчийн гаргасан саналыг харгалзан шүүх эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтод нийцүүлэн шүүгдэгчид цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авч болно.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэг хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх ... хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж заасныг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 4

Бүгд: 15

73.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 17 цаг 23 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. “Алт-3” аяныг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2025 оны 85 дугаар тогтоолд хэсэгчлэн тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хориг

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга А.Үйлстөгөлдөр, мөн газрын Хуулийн бодлогын газрын дарга Ж.Мөнхболд, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зөвлөх Г.Ганболд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, мөн албаны зөвлөх Г.Алтанцэцэг, Д.Нямбаяр, референт

Б.Баярсайхан, Хүний эрхийн дэд хороо хариуцсан референт Л.Хурцбилэг нар байлцав.

“Алт-3” аяныг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын 2025 оны 85 дугаар тогтоолд хэсэгчлэн тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийн талаар танилцуулгыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга А.Үйлстөгөлдөр танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр, Г.Уянгахишиг, О.Алтангэрэл, Ц.Сандаг-Очир нарын тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга А.Үйлстөгөлдөр, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зөвлөх Г.Ганболд, Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар, Д.Ганбат, Ц.Сандаг-Очир, Д.Цогтбаатар нар үг хэлэв.

Д.Цогтбаатар: Монгол Улсын Их Хурлын 2025 оны 85 дугаар тогтоолын 1 дэх заалтын 5 дахь дэд заалтад хэсэгчлэн тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хүлээж авах нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	11
Татгалзсан:	6
Бүгд:	17

64.7 Гуравны хоёроор хураалгах санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	11
Татгалзсан:	6
Бүгд:	17

64.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Д.Цогтбаатар: Монгол Улсын Их Хурлын 2025 оны 85 дугаар тогтоолын 1 дэх заалтын 5 дахь дэд заалтад хэсэгчлэн тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хүлээж авах нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн:	13
Татгалзсан:	4
Бүгд:	17

76.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Д.Цогтбаатар: Монгол Улсын Их Хурлын 2025 оны 85 дугаар тогтоолын 3 дахь заалтад хэсэгчлэн тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хүлээж авах нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 4
Бүгд: 17
76.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 18 цаг 14 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 24 минут үргэлжилж, ирвэл зохих 25 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 68.0 хувийн ирцтэйгээр 18 цаг 14 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Д.ЦОГТБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:
ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

2025 ОНЫ 09 ДҮГЭЭР САРЫН 17-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 09 дүгээр сарын 17-ны өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”
танхим
16 цаг 50 минут.

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Д.Цогтбаатар: Гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе. Намрын чуулган эхэлснээс хойш Хууль зүйн байнгын хорооны анхны хуралдаан эхэлж байна.

Гишүүддээ шинэ чуулган эхэлсний мэндийг хүргэж, Байнгын хороо энэ чуулганаар бас нэлээн завгүй ажиллах ийм ажлын төлөвлөгөөтэй байгааг гишүүддээ сануулмаар байна.

Ингээд Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Хууль зүйн байнгын хорооны 2025 оны 9 дүгээр сарын 17-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя.

Дамдины Цогтбаатар, Оюунсайханы Алтангэрэл, Хүрэлбаатарын Баасанжаргал, Энхбаярын Батшугар, Баярмагнай Баярбаатар, Борхүүгийн Дэлгэрсайхан, Мөнхтөрийн Нарантуяа-Нара гишүүн, Одсүрэнгийн Номинчимэг, Бөхчулууны Пүрэвдорж гишүүн, Цэндийн Сандаг-Очир гишүүн, Лхагвасүрэнгийн Соронзонболд, Ням-Осорын, Гончигдоржийн Уянгахишиг, Баттөмөрийн Энхбаяр, Сүхбаатарын Эрдэнэболд гэсэн гишүүд ирж, ирц 56 хувьтайгаар ирцийн шаардлага хангагдсан байна. Ингээд ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Хэлэлцэх 2 асуудал байгаа.

Нэгдүгээр асуудал Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 07 дугаар сарын дүгнэлт, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн холбогдох заалт, 14.10 дугаар зүйлийн 11, 12 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай.

Хоёрдугаар асуудал “Алт-3 аяныг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2025 оны 85 дугаар тогтоолд хэсэгчлэн тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хориг гэсэн ийм 2 асуудал байна.

Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүн байна уу?

Алга байна.

Ингээд хэлэлцэх асуудалдаа батлагдлаа. Хэлэлцэх асуудалдаа орьё. Нэгдүгээр асуудал. Байз энэ дээр.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 07 дугаар дүгнэлтийн талаарх товч танилцуулгыг та бүхэнд хийе.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 07 дугаар дүгнэлт.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн холбогдох заалт, 14.10 дугаар зүйлийн 11, 12 дахь хэсэг, Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13, 14 дэх заалт, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг зөрчсөн эсэх маргааныг Улсын Их Хурлын Цэц 2025 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн дунд суудлын хуралдаанаараа хянан хэлэлцсэн бөгөөд уг маргаанд Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг Монгол Улсын Их Хурлаас итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдон Цэцийн дунд суудлын хуралдаанд хариу тайлбар гаргаж оролцсон болно.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Баясгалан даргалж, Үндсэн хуулийн цэцийн гишүүн Гангабаатар, Мөнхсайхан, Цолмон, Батрагчаа нар болон мэдээлэл гаргагч нарын бүрэлдэхүүнтэй хуралдсан болно.

Үндсэн хуулийн цэцэд мэдээлэл, гомдол гаргагч нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт энэ зүйлийн 1.5-д заасан таслан сэргийлэх арга хэмжээг шүүх авна гэж 14.10 дугаар зүйлийн 11 дэх хэсэгт эрүүгийн хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх явцад прокурор оролцогчийн гаргасан саналыг харгалзан шүүх эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтод нийцүүлэн шүүгдэгчид цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээ авч болно гэж, мөн зүйлийн 12 дахь хэсэгт эрүүгийн хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх явцад шүүгдэгчийг цагдан хорьсон хугацаа нь энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан хугацаанд хамрахгүй гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалтын халдашгүй чөлөөтэй байх, хуульд заасан үндэслэл журмаас гадуур дур мэдэн хэнийг ч баривчлах, хорих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. Хэнд боловч эрүү шүүлт тулгаж болохгүй. 14 дэх заалтад шударга шүүхээр шүүлгэж, шүүхийн шийдвэрийг давж заалдах эрхтэй. Гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно. 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц хууль зүйн баталгааг бүрдүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна гэж заасныг зөрчиж байна. Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалтад зааснаар иргэний эрх чөлөөг нь хязгаарлаж хорихын тулд хуульд заасан тодорхой үндэслэл байх ёстой.

Гэтэл Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.9 дүгээр зүйлд яллагдагчийг цагдан хорих үндэслэлийг нэг бүрчлэн тодорхой заасан боловч шүүгдэгчийг цагдан хорих үндэслэлийг уг хуульд тодорхой заагаагүй. Хорих арга хэмжээ ял шийтгэл нь тэр дундаа хаалттай хорих нь Монгол Улсад төдийгүй олон улсад хамгийн хатуу ял, арга хэмжээнд хамаардаг.

Хүнийг хорих эрхийг ялангуяа шүүхээс гэм буруу нь эцэслэн тогтоогдоогүй байгаа иргэнийг хорих эрхийг шүүхэд олгодог энэ хууль нь ойлгомжтой, тодорхой үндэслэлтэй байх ёстой. Хуулийг хэрэгжүүлэхэд холбогдох албан тушаалтны санаатай, санамсаргүй алдаа гарч, хуулийн зохицуулалт зөрчигдөж байхыг үгүйсгэхгүй ч аль болох алдаа гаргахгүйгээр уншаад нэг мөр ойлгож хэрэгжүүлэх боломжтой. Хүний эрх, эрх чөлөөг хангахуйц хууль зүйн үндэслэлтэй тодорхой зохицуулалт бүхий хуулийг батлах нь төрийн үндсэн үүрэг юм.

Гэтэл тус хуулийн 14.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт шүүгдэгчийг цагдан хорих эрхийг шүүхэд олгохдоо аливаа үндэслэл, журам заагаагүй талаар дурдсан байна.

Улсын Их Хурлын итгэмжлэл итгэмжилсэн төлөөлөгчийн Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд хүргүүлсэн тайлбарт Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.10 дугаар зүйлд яллагдагчийг цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээ авах талаар зохицуулсан бөгөөд шүүхийн шатанд хэргээс шийдвэрлүүлэхээр хүлээж байгаа шүүгдэгчийн хувьд цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээ хэрэглэх процессыг хуульчлахдаа шүүгдэгчид цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээ авах эсэхийг прокурор оролцогчийн гаргасан саналыг харгалзан шүүхийн хэлэлцүүлгийн үндсэн дээр шийдвэрлэхээр заасан.

Өөрөөр хэлбэл, прокурор болон оролцогч нь хуульд заасан үндэслэл нөхцөлийн дагуу хуульд заасан шаардлагыг хангасан саналыг шүүхэд гаргах, шүүх уг саналыг үндэслэн цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээ авах, гаргах, шүүх уг саналыг үндэслэн цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах талаарх зохицуулалтыг тус хуулиар тогтоож өгсөн нь тодорхой байна.

Иймд тус хуулийн 14.10 дугаар зүйлийн 11 дэх хэсгийг иргэний мэдээлэлд дурдсан шүүгдэгчийг цагдан хорих үндэслэл, журмыг тодорхой заахгүйгээр ерөнхий агуулгаар, хугацаагүй хорих боломж, эрхийг шүүхэд олгосон гэж үзэх үндэслэлгүй байна. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.1 дүгээр зүйлд зааснаар анхан шатын шүүхийн шүүгч нь прокуророос шүүхэд шилжүүлсэн хэргийг хүлээж авснаас хойш 15 хоногийн дотор яллагдагчийг шүүхэд шилжүүлэх эсэх асуудлыг шийдвэрлэх, мөн 32.2 дугаар зүйлд зааснаар яллагдагчийг шүүхэд шилжүүлэх шийдвэр гарснаас хойш 14 хоногийн дотор хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлж эхлэх үүрэгтэй бөгөөд дээрх зохицуулалтын хүрээнд шүүгдэгчид авсан цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээний нийт хугацааг тодорхойлохоор байна.

Давж заалдах болон хяналт шатны шүүхийн хяналтын шатны шүүхийн хувьд тус хуулийн 39.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 40.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу хэргийг хүлээж авснаас хойш 30 хоногийн дотор хянан шийдвэрлэхээр хуульчилсан бөгөөд, мөн хуулийн 36.11 дүгээр зүйлд шүүгдэгчийг цагаатгасан, ял эдлэхээс чөлөөлсөн, ял оногдуулахгүйгээр тэнссэн, эсхүл түүнд хорихоос өөр төрлийн ял оногдуулсан хэргийг хэрэгсэхгүй болгосон бол цагдан хоригдож байгаа шүүгдэгчийг суллахаар заасан тул шүүхийн шийтгэх тогтоол, хуулийн хүчин төгөлдөр болтол цагдан хорих арга хэмжээ авагч нь авагдсан шүүгдэгчийн хувьд дээрх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээнд түүний цагдан хорих хугацаа тоологдохоор байх бөгөөд хэргийн ээдрээ төвөгтэй

байдлаас шалтгаалан шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаа сунгах журмыг тус хуулийн 33.1 дүгээр зүйлийн 2, 39.20 дугаар зүйлийн 2, 40.3 дугаар зүйлийн холбогдох хэсэгт тусгайлан хуульчилсан.

Түүнчлэн сэжигтэн, яллагдагчийн баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэгт баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, энэ хууль тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт хоригдох этгээдийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу эрх бүхий албан тушаалтнаас гаргасан шийдвэрт заасан хугацаагаар хорино. 44 дүгээр зүйлийн 44.2 дахь хэсэгт хорих байрны дарга нь хоригдсон этгээдийн хуульд заасан хорих хугацаа дуусах болсон тухай 24 цагаас доошгүй хугацааны өмнө хорих шийдвэр гаргасан албан тушаалтанд болон харьяалах прокурорт бичгээр мэдэгдэх үүрэгтэй.

Түүнчлэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт яллагдагчийн цагдан хорих үндсэн хугацаа 1 сар байна. Мөн зүйлийн 2 дахь хэсэгт шүүх цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээний хугацааг тухай бүр 1 сар хүртэл хугацаагаар сунгах гэж тус тус зааснаас үзэхэд цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээний хугацааны хязгаарлалтыг тогтоогоогүй гэж үзэх үндэслэлгүй байна.

Дээр дурдсан зохицуулалтуудын агуулгаас харахад иргэний мэдээлэлд тусгасан үндэслэл нь хууль хэрэглээнд гарсан буруу жишгээс хамааралтай гэж үзэх үндэслэлтэй байх бөгөөд /уучлаарай/ шүүгдэгчийг цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээг хэрхэн хэрэгжүүлэх талаар нарийвчилсан процессыг хуульчлаагүй. Мөн 14.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 14.10 дугаар зүйлийн 11, 12 дахь хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13, 14 дэх заалт, 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг зөрчсөн гэж үзэх үндэслэлгүй байна гэсэн байна.

Үндсэн хуулийн цэц уг маргааныг хэлэлцээд

1. Эрх зүйн тодорхой байдлыг хангасан эсэх
2. Шүүгдэгчийг цагдан хорих үндэслэлийг тодорхой заасан эсэх
3. Шүүгдэгчийг цагдан хорих журмыг хуульд тодорхой заасан хэрэг
4. Тохирсон байх зарчмыг хангасан эсэх.
4. Дур мэдсэн эсэх.
5. Шүүгдэгчийг шүүхийн хяналтад байх зарчим хангагдсан эсэх

6. Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх гэсэн 6 үндэслэлийн хүрээнд дараах дүгнэлтийг гаргасан байна.

Дүгнэлт

1.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.10 дугаар зүйлийн 11 дэх хэсэгт эрүүгийн хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх явцад прокурор оролцогчийн гаргасан саналыг харгалзан шүүх эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтод нийцүүлэн шүүгдэгчийг цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээ авч болно гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалтад халдашгүй чөлөөтэй байх эрхтэй, хуульд заасан үндэслэл журмаас гадуур дур мэдэн хэнийг ч баривчлах, хорих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. Баривчилсан шалтгаан, үндэслэлийг баривчилсан хүн, түүний гэр бүлийнхээ өмгөөлөгчид нь хуульд заасан хугацаанд мэдэгдэнэ. Мөн зүйлийн 14 дэх заалтад шударга шүүхээр шүүлгэх эрхтэй, 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна гэснийг тус тус зөрчсөн байна.

2.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт энэ зүйлийн 1.5-д заасан таслан сэргийлэх арга хэмжээг шүүх авна гэж, 14.10 дугаар зүйлийн 12 дахь хэсэгт эрүүгийн хэргийг шүүхэд хянан шийдвэрлэгдэх явцад шүүгч шүүгдэгчийг цагдан хорих хугацаа нь энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан хугацаанд хамаарахгүй гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13, 14 дэх заалт, 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг тус тус зөрчөөгүй байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.10 дугаар зүйлийн 11 дэх хэсгийг Үндсэн хуулийн цэцэд маргаан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу 2026 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй гэжээ.

Ингээд танилцуулгыг танилцуулж дууслаа. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Энэ бол дүгнэлт өөрөө 33 хуудас байгаа шүү дээ. Бид нар энийг ингээд товчлоод үндсэн агуулгуудыг нь сая танилцуулж байгаа юм. Сайнзориг гишүүн маань өөрөө ажилдаа өнөөдөр яг ажил давхцаад ирэх боломжгүй байгаа учраас бид нар бас өмнөөс нь танилцуулж байна.

Ингээд Цэцийн 2025 оны 07 дугаар дүгнэлтийг гишүүдэд бас тараасан байгаа. Үндсэн хуулийн цэцийн дүгнэлттэй холбогдуулан итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү. Өөрөө харин тийм байхгүй. Гэхдээ яах вэ эндээ бид нар материалаа танилцчихсан юм чинь. Айн? Үг за тэгье.

Ингээд Алтангэрэл гишүүнээр тасаллаа. Энхбаяр гишүүний микрофоныг өгье.

Б.Энхбаяр: Гишүүдийнхээ оройн амгаланг айлтгая. Үндсэн хуулийн энэ цэцийн дүгнэлт бол цагдан хорих үндэслэлийг хуульд илүү тодорхой заагаач ээ гэдэг агуулгаар гарсан дүгнэлт юм байна. Цагдан хорих үндэслэлийг хууль тогтоогч аль болох тодорхой заах чиглэлд эрмэлзэж ирсэн байдаг. 2002 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх, Эрүүгийн байцаан шийтгэх хуульд оргон зайлж

болзошгүй, дахин гэмт хэрэг үйлдэж болзошгүй гэдэг байдлаар тодорхой үндэслэлүүдийг заасан ирсэн байдаг. Энийг дараа дараагийн хууль тогтоогчид илүү боловсронгуй болгоод хамгийн сүүлд миний хувьд мөн 24 оны, 23 оны 11 сард мөн цагдан хорих үндэслэлийг бас тодорхой болгох чиглэлд хуулийн төсөл санаачилж, хөнгөн гэмт хэрэгт цагдан хорихгүй байх, зөвхөн хүнд гэмт хэрэгт цагдан хорих, ингэхдээ 4 үндэслэлээр цагдан хорих үндэслэлийг илүү тодорхой болгох чиглэлээр хуулийн төсөл санаачилж батлуулж байсан байдаг. Энийг тодорхой болгох дээр бас нэлээн учиртай.

Яагаад гэхээр энэ амьдрал баялаг ч гэж ярьдаг. Гэмт хэрэг, тохиолдол, үйлдэл, учир шалтгаан, хохирогч, гэмт хэрэг үйлдэгчийн зан байдал, арга хэлбэрүүд бүгд өөр өөр байдаг учраас хуулийг их тодорхой болгочихоор, биччихээр тэгвэл тэрнээс өөр нөхцөл байдал гарвал яах вэ гэдэг ийм асуудлууд гараад байдаг. Тийм ч учраас хууль тогтоогч хуулийг хэрэглэж байгаа байгууллага нь шүүх учраас амьдралын уян хатан нөхцөл байдал үүссэн тохиолдолд шүүгч уян хатан байдлаар шүүгчийн дотоод итгэлээр хэрэглэх тэр боломжийг нээж бичсэнийг сая Цэц илүү тодорхой болгоо л гэж хэлж байгаа юм байна.

Тийм учраас хүлээж авсан тохиолдолд би Байнгын хорооноос нэлээн ажлын хэсэг гаргаж шүүгч, прокурор, мөрдөх албадаас, мөн шинжилгээ, судалгааны байгууллагуудаас хүмүүс оруулж хуулийн төслийг санаачлахгүй бол энэ бас их цаанаа их үр дагавартай. Яагаад гэхээр гэмт хэрэгтнээ бид нар алдчих бас аюултай. Ялангуяа залилан, хулгай гэсэн үргэлжилсэн хэлбэрээр гэмт хэрэг үйлддэг этгээдүүд энэ цонхоор гадагшаа зугт.../минут дуусав./

Д.Цогтбаатар: Энхбаяр гишүүн ээ нээрээ энд үг хэлэх боломж бас байгаа юм байна шүү. Тийм учраас байгаа тийм тэгэхдээ нэмээд та юу яах уу? Тэгье Энхбаяр гишүүний микрофоныг өгье.

Б.Энхбаяр: Тийм боломжийг бас хадгалж байхгүй бол бас болохгүй байдаг. Нөгөө талдаа цагдан хорихыг буюу хорьж мөрдөх аргыг түлхүү хэрэглэх ч байсан 2002 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг бид нар улам илүү хүнлэг талд нь, хүний эрх талд нь хангасаар л ирсэн. Тухайлбал, би статистик хэлье 2002 оны Эрүүгийн хууль, 2015 оны Эрүүгийн хууль хэрэгжиж эхэлсэн 17 оны 7 сарын 01-ний хүртэлх хугацаанд цагдан хоригдсон 5 хүний 4 нь шүүх рүү шилжээгүй байдаг юм. Цагдан хоригдсон 5 хүний 1 нь л шүүх рүү явсан. Өөрөөр би бид нар гэм буруугүй 5 хүний 4-ийг хорьж байсан гэсэн үг.

Харин 2017 оны хуулиас хойшоо цагдан хоригдсон 5 хүний 3 шүүх рүү явж гэм буруутай гэж тооцогдсон. Өөрөөр хэлбэл хорьж мөрдөх тэр.../минут дуусав./

Д.Цогтбаатар: Гүйцээгээд наадах чинь яг чухал юм ярьж байна. Энхбаяр гишүүнд микрофон гүйцээгээд өгье.

Б.Энхбаяр: Бид нар цагдан хорих тэр үндэслэл, шалгуураа илүү тодорхой болгох тусам мөрдөх байгууллагуудад тавигдаж байгаа тэр стандарт шаардлагууд мөн сайжирч байна гэсэн үг. Тэгэхдээ бас нөгөө талд нь бас үзүүлэлт байдаг. Мөрдөх албадын зүгээс шалгаж байгаа хэргийн оролцогчдоо алдаад мөрдөн шалгах ажиллагаанаас зугтаж байгаа оргон зайлсан гэмт хэрэгтнүүдийн тоо нөгөө талаараа бас нэмэгдсэн ийм статистик мэдээлэл бас байдаг юм. Тийм учраас бид

нар яг энэ 2 баланс дээр хууль тогтоогч судалгаа, шинжилгээ, үндэслэлийг тодорхой ажлын хэсэг гаргаж байж хэрэв Цэцийн дүгнэлтийг хүлээж авах юм бол ажлын хэсэг гаргаж байж нэлээн ултай, суурьтай ярьж байж хуулийн төсөл санаачилж батлаасай гэсэн ийм саналтай байна. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Алтангэрэл гишүүний микрофоныг өгье.

О.Алтангэрэл: Энхбаяр гишүүнтэй ерөнхийдөө санал давхцаж байна даа. Тэгэхдээ зарим зүйлийг бас хэдүүлээ тодорхой ярих ёстой болж байгаа юм. Ер нь яагаад ийм гомдол гарах болов гээд үзэхээр үндсэндээ шүүгдэгчийг цагдан хориог нь сунгана гэдэг асуудал ерөөсөө автоматаар юм шиг явж ирсэн. Ерөөсөө хэрэг хэлэлцлээ, шүүх хуралдаан хойшиллоо, шүүгчид авсан цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээ хэвээр үргэлжлүүлсүгэй гээд л ингээд л заачихдаг. Энэ сүүлдээ юу болж хувирав гэхлээр өмгөөлөгчид ажил гарна. Өмгөөлөгч гэдэг чинь өөрөө өөрөө олон хэрэгтэй, олон төрлийн нийгмийн харилцаанд оролцдог. Өмгөөлөгчдийн сургалт боллоо. Тэгээд би энд оролцож чадахгүй нь гээд бичиг өгөхөөр тэгвэл өмгөөлөгчийгөө иртэл гэдэг байдлаар, өмгөөлөгч чинь байхгүй гэдэг байдлаар цагдан хорьчихно. Хойшлуулах хүсэлт гаргана. Энэ асуудлуудыг тодруулмаар байна шүүгч ээ. Гадуур шалгагдаж байгаа хүн шүү дээ. Тэгвэл яах вэ хорьж байгаад хийнэ ээ та нар яасан их хойшлуулдаг юм гээд ингээд цагдан хорьчихдог. Энэ болгоныг буруутгах гэхээр нөгөө хууль маань ерөнхий. Анх эхлээд хүнийг цагдан хорих дээр өмгөөлөгч нь гомдол гаргаж байгаа юм, 10 хоноод гомдол гаргаж болж байгаа юм манай Энхбаяр гишүүний ярьдаг үнэн л дээ манай эрүүгийн процесс их том өөрчлөлт хийсэн Их Хурлаас. Тэгээд энэнийхээ дагуу анх цагдан хоригдож байгаа хүний нөхцөл байдал ер нь нэлээн сайжирсан. Шүүгдэгчийн хувьд асуудал нэлээн зовлонтой байгаа.

Дээрээс нь энэ орон нутгийн асуудал байгаа. Давж заалдах шатын шүүх хуралдаанд бүрэлдэхүүн хүрэхгүй гэдэг асуудал байгаад байна. Тэгээд аймаг дундуур явна. Шүүгч ер нь бүрэлдэхүүн байхгүй ээ гээд ингээд тэгээд л нөгөө автоматаар сунгадаг юм нь үргэлжлээд явчихдаг. Тэгээд Улсын дээд шүүхээс саяын тэр Үндсэн хуулийн цэцийн маргаан дээр тайлбар өгөхдөө жишээлбэл ингэж тайлбарласан байгаа байхгүй юу. Шүүхийн практикт шүүгдэгчид цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээг голчлон шүүхийг үл хүндэтгэж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн, оргон зайлсан, эс үгүй бол оргон зайлахыг завдсан, дахин гэмт хэрэг, зөрчил үйлдсэн, эс үгүй бол үйлдэж болзошгүй тухай үндэслэл бүхий нөхцөл байдал тогтоогдсон, гэрч, хохирогчид хууль бусаар нөлөөлсөн, эс үгүй бол тэдний аюулгүй байдалд заналхийлсэн, шүүгдэгчийн өөрийнх нь аюулгүй байдлыг хамгаалах шаардлага үүссэн зэрэг үндэслэлүүдээр авч байна гээд.

Тэгэхдээ энийг нь хаана ч хуульчлаагүй учраас үндсэндээ шүүх дээр ийм заншлын хэм хэмжээ нь давамгайлаад ингээд сонгогчдын эсвэл өмгөөлөгч нь оролцохгүй бол ингээд цаашаагаа ер нь ингээд хорьж байгаад хурлыг нь хийлгэнэ ээ яасан их хойшлуулдаг юм гэдэг ийм асуудал руу яваад байдаг учраас бид энэ Цэцийн дүгнэлтийг хүлээж авах нь зүйтэй. Хүлээж аваад бид яг ажлын хэсэг гаргаж энэ дээр маш сайн ажиллах ёстой гэдэг нь үнэн.

Дээрээс нь бас нэг зүйлийг бас зориуд тэмдэглэж хэлмээр байгаа юм. Сүүлийн үед энэ Үндсэн хуулийн цэцээс гарч байгаа шийдвэрүүд маш ултай,

суурьтай дүгнэлттэй, энэ үндэслэж байгаа хэсгээ маш нарийн бичсэн, нэлээн чамбай гарч байгаа. Тэгээд энэ дээр нь бас Үндсэн хуулийн цэцийг бас сайшаалтай байна гэж хэлэх гэсэн юм. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Тэгэхлээр асуулт асууж, энэ чинь үг, асуулт нэгтгээд хэлчихлээ гэж үзэх үү? Тэгвэл энэ асуудлаар үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү.

Баасанжаргал гишүүнээр тасаллаа. Баасанжаргал гишүүний микрофоныг өгье.

Х.Баасанжаргал: Өнөөдөр үг хэлэхгүй бол алдас болно шүү дээ. Өнөөдөр өмгөөлөгчдийн баярын өдөр. Тийм учраас тийм, тийм учраас бас микрофон дээр нийт өмгөөлөгч нартаа баярын өдрийн мэндийг бас хүргэх нь зөв байх гэж бодож байна. Тэгээд Хууль зүйн байнгын хорооны нийт гишүүдийн зүгээс баярын мэнд хүргэе ээ гээд.

Цэцийн дүгнэлтийг би хүлээж авах нь зүйтэй гэж бодож байна. Бодох ч юу байх вэ үндэслэл бүхий дүгнэлтийг бол гаргасан байна. Яг практик дээр шүүгдэгч, сэжигтэн, яллагдагч гээд эдгээр хүмүүсийг цагдан хорих асуудал үнэхээр зарим тохиолдолд яг субьектив байдлаар шийдэгдэж ирдэг ийм асуудлууд байгаа. Үүнийг нь ч гэсэндээ олон улсын байгууллагаас ирсэн шинжээч дүгнэлтээрээ бол бас нэлээн сайн хангалттай тогтоосон байдаг.

Дээрээс нь энэ нь өөрөө бас шүүхийн хяналт бол зайлшгүй шаардлагатай нарийвчилсан үндэслэл бүхий эдгээр зүйлүүдтэй өмгөөлөгчийг зайлшгүй танилцуулах ёстой гэдэг ийм дүгнэлтийг Монгол Улс авчхаад байгаа. Тэгээд эндээ бас өнгөрсөн хавар батлагдсан хуулиар бол манай парламент бол бас энэ алдааг залруулсан гэж ойлгож байгаа.

Хоёрдугаарт гэвэл нэг зүйлийг бас хэлэх хэрэгтэй. Цаашид бид нар нэг зүйл дээр анхаарах ёстой. Ялангуяа энэ шүүгдэгчийн цагдан хорих хугацааны асуудал 24, нийт цагдан хорих хугацаа 24 сар гэж байгаа боловч яг бодит амьдрал дээр 24 сар хэтэрдэг ийм тохиолдлууд маш их байдаг. Үүнийг тайлбарлахдаа шүүгдэгч гэж байгаа учраас энэ нөгөө яллагдагчийн 24 сар үйлчлэхгүй ээ гээд ингээд үгийн утгаар нь тайлбарлаж явдаг ийм гажуудал бол байгаа. Энэ бол нэлээн олон жил үргэлжилж байгаа. Энэ асуудлаар бас урьд нь бас гомдол санал гаргаж байсан боловч энэ асуудал яг хэвээрээ явж байгаа. Тэгээд энэ асуудал дээр бол би Цэцийн энэ дүгнэлтийг хүлээж аваад, хүлээж аваад тодорхой нөхцөлүүдээ маш тодорхой томьёолох, хууль дээр томьёолох хэрэгтэй гэдгийг зориуд бас гишүүддээ бас анхаараад энийг дэмжээсэй гэж хүсэж байна.

Д.Цогтбаатар: Баасанжаргал гишүүнд баярлалаа. Нээрээ өмгөөлөгчдийн өдрийг тохиолдуулаад Монголын бүх өмгөөлөгчдөдөө иргэдийнхээ эрхийн төлөө төрөөс аливаа нэгэн хүний эрхийг зөрчсөн үйлдэл гаргахгүй байхын төлөө тангараг өргөөд сэтгэл зүрхээрээ ажиллаж байгаа энэ өмгөөлөгчдөдөө бас бид нар баяр хүргэх ёстой байх. Ялангуяа Хууль зүйн байнгын хороо энэ дээр бид нар, бүгдээрээ санал нэгтэй өмгөөлөгчдийнхөө бас санаа бодлыг байнга сонсож явдаг. Бас хилчдийн баярын өдөр юм байна. Нээрээ улсын хилийн манаандаа зогсож байгаа бүх хилчдэдээ бас давхар баяр хүргэе.

Тэгээд энэ дээр би нэг зүйл бас нэмээд хэлмээр байна. Ер нь саяын үг хэлсэн гишүүдтэй би яг санал нэг байна. Үндсэн хуулийн цэцийн зүгээс хорих дээр ер нь ямар ч асуудал яриагүй. Зөвхөн энийг илүү нарийвчлах хэрэгтэй байна. Яагаад гэвэл яах аргагүй хүний эрх рүү халдаж байгаа энэ юман дээр ямар нэгэн нүх сүв үлдээж болохгүй ээ гэдэг асуудал гарч байгаа. Яг тэгээд энэ нөгөө практик дээр манайх ч гэсэн эндээс өгч байсан тайлбар дээрээ практик дээр буруу хэрэглээ байгаад байгаа болохоос биш хуульд байхгүй байна гээд бид нар энэ дээр ярьж байна шүү дээ Их Хурлаас очсон төлөөлөгч маань. Тэгээд сая яг энэ практик дээр байсан өмгөөлөгч, хуульчид маань ярьж байна. Яасан Их Хурал хойшлуулдаг юм гэж байгаад л сунгана гэдэг чинь жинхэнэ том яг тэр практик дээр гарч байгаа асуудлыг тэр яасан их гэж зууж хүний эрх рүү халдах үүд хаалга хаалттай байх ёстой байхгүй юу. Тэгэхлээр яг тэр дээр, амьдрал дээр яг ч тийм байж байгаа. Тийм учраас энэ дээр уртаашаа л ерөөсөө хүсэж байгаа зүйл нь энийгээ илүү тодорхой болгооч. Тэгээд Энхбаяр гишүүний түрүүний хэлж байгаа яг зөв. Энэ дээр яах аргагүй ажлын хэсэг гаргаж маш нямбай ажиллахгүй бол болохгүй. Яагаад гэвэл нээрээ л яг тэр хүний суурь эрх рүү энэ чинь халдаж байгаа төрийн процедурыг бид нар илүү нарийвчилж өг. Төр өөр дээрээ яг ийм асуудал дээрээ илүү шаардлага, шалгуур тавьж өгөх л ёстой. Тэр өнцгөөсөө бид нар энийг бас би хувьдаа дэмжиж байгаа юм Үндсэн хуулийн цэцийн саналыг. Тэгээд энэ өнцгөөсөө хэдүүлээ харж ажиллах нь зөв байх гэж гэж бодож байна.

Тэгвэл ингээд үг хэлж дууслаа. Цэцийн дүгнэлттэй холбогдуулж тэгвэл санал хураалтдаа орьё.

1.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.10 дугаар зүйлийн 11 дэх хэсэгт эрүүгийн хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх явцад прокурор оролцогчийн гаргасан саналыг харгалзан шүүх эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтод нийцүүлэн шүүгдэгчид цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээ авч болно гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалтад халдашгүй чөлөөтэй байх эрхтэй, хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч баривчлах, хорих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. Баривчилсан шалтгаан, үндэслэлийг баривчлагдсан хүн, түүний гэр бүлийнхэн, өмгөөлөгчид нь хуульд заасан хугацаанд мэдэгдэнэ гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Ингэе гишүүдээ бэлтгэл, санал хураахдаа бэлтгэе. Санал хураалт.

73.3 хувиар санал дэмжигдлээ.

2.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.10 дугаар зүйлийн 11 дэх хэсэгт эрүүгийн хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх явцад прокурор оролцогчийн гаргасан саналыг харгалзан шүүх эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтод нийцүүлэн шүүгдэгчийг цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээ авч болно гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад шударга шүүхээр шүүлгэх эрхтэй гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтдаа бэлдье гишүүд ээ. Одоо санал хураалт.

73.3 хувиар санал дэмжигдлээ.

3 дахь санал хураалт. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.10 дугаар зүйлийн 11 дэх хэсэгт эрүүгийн хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх явцад прокурор оролцогчийн гаргасан саналыг харгалзан шүүх эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтод нийцүүлэн шүүгдэгчид цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээ авч болно гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, хэсэгт төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

73.3 хувиар санал дэмжигдлээ.

Сайнаа юу? Тэгвэл Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 07 дугаар дүгнэлтийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг танилцуулна.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 07 дугаар дүгнэлтийг хэлэлцэж дууслаа. Дараагийн асуудалдаа оръё.

17.23 цаг

““Алт-3” аяныг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2025 оны 85 дугаар тогтоолд хэсэгчлэн тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хэлэлцье.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Хуралдаанд Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Алтанхуягийн Үйлстөгөлдөр, Ерөнхийлөгчийн зөвлөх Гочоогийн Ганболд, Улсын Их Хурлын Ерөнхийлөгчийн Тамгын газрын Хуулийн бодлогын газрын дарга Жаргалсайханы Мөнхболд гэсэн ажлын хэсгийн гишүүд ирж оролцож байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Алтанхуягийн Үйлстөгөлдөрт танилцуулна. Үйлстөгөлдөр даргын микрофоныг өгье 5 дугаар микрофон.

А.Үйлстөгөлдөр: Улсын Их Хурлын дарга, Байнгын хорооны дарга, Улсын Их Хурлын байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 8 дахь хэсгийг тус тус үндэслэн ““Алт-3” аяныг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 25 оны 85 дугаар тогтоолд дараах үндэслэлээр Монгол Улсын Ерөнхийлөгч хэсэгчилсэн хориг тавьж байна. Үүнийг танилцуулъя.

1.Монгол Улс тусгай хамгаалалтад авсан газар нутгийг нэмэгдүүлж, байгаль орчноо хамгаалах бодлого баримтлах ёстой. Монгол Улсын Их Хурлын 25 оны 85 дугаар тогтоолын 5 дугаар заалтад алтны үндсэн ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулах зорилгоор Их Хурлын 20 оны 46, 47 дугаар тогтоолуудад өөрчлөлт оруулах төслийг боловсруулж, Улсын Их Хуралд яаралтай өргөн мэдүүлэхээр тусгасан байна.

Энэхүү яаралтай өргөн мэдүүлж өөрчлөлт оруулахаар дурдсан. Монгол Улсын Их Хурлын 20 оны 46, 47 дугаар тогтоолууд нь зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авч, тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг нэмэгдүүлсэн байна.

Үндэсний баялгийн сангийн хуримтлалыг нэмэгдүүлэх бодлого тууштай хэрэгжих нь зүйтэй боловч энэ хүрээнд алтны үндсэн ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулах зорилгоор улсын тусгай хамгаалалтад авсан газар нутаг, түүний хилийн заагийг өөрчилж, тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг багасгах хууль зүйн нөхцөл боломжийг бүрдүүлсэн байна.

Түүнчлэн Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд заасны дагуу экологийн аюулгүй байдлыг хангах, түүний тэнцвэрийг хадгалах, байгаль орчин, ой, усны сан бүхий газрыг хамгаалах, цөлжилттэй тэмцэх нь үндэсний аюулгүй байдлын нэгэн бүрэлдэхүүн хэсэг бөгөөд нэн ховор, ховор болон эко системд онцгой үүрэгтэй амьтан, ургамал бүхий газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авч тэдгээрийн амьдрах орчныг тэтгэхэд биотехникийн аргыг түлхүү хэрэглэхээр тусгасан байдаг.

Иймд байгаль орчны талаарх төрийн бодлого, цаашид өнөөгийн улсын тусгай хамгаалалтад авсан газар, нутгийн хэмжээг нэмэгдүүлэх зарчмыг тууштай баримтлах нь зүйтэй.

2.Монгол Улсын Үндсэн хуулийн зарчимд тогтоол нийцэх нь зүйтэй. Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д Улсын Их Хурлын баталсан хууль, бусад шийдвэрт бүхэлд нь буюу зарим хэсэгт нь хориг тавих, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт Улсын Их Хурлын баталсан хууль, бусад шийдвэрт Үндсэн хуулийн Гучин гуравдугаар дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д зааснаар бүхэлд нь буюу зарим хэсэгт нь хориг тавина хэмээн тус тус Монгол Улсын Ерөнхийлөгчийн үндсэн бүрэн эрхэд заасан байдаг.

Мөн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.5 дахь хэсэгт энэ хуулийн 46.4-д заасны дагуу илгээсэн хуулийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар хүлээж авсан өдрөөс хойш ажлын 5 өдөрт багтаан Монгол Улсын Ерөнхийлөгч тухайн хууль, тогтоолыг бүхэлд нь буюу түүний зарим хэсэгт хориг тавих эсэх асуудлыг шийдвэрлэнэ гэж заасан.

Тэгвэл Монгол Улсын Их Хурлын 25 оны 85 дугаар тогтоолын 3 дугаар зүйлд энэ тогтоолыг Монгол Улсын 25 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй хэмээн заасан нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль болон

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн холбогдох хэсэгт заасан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хориг тавих эрхийг зөрчих шинжийг агуулсан байна.

Иймд дээр дурдсан үндэслэлээр “Алт-3” аяныг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 25 оны 85 дугаар тогтоолд хэсэгчлэн тавьсан хоригийг холбогдох хуулийн дагуу хэлэлцэн шийдвэрлэнэ үү.

Баярлалаа.

Д.Цогтбаатар: Үйлстөгөлдөр даргад баярлалаа. Монголын Улсын Ерөнхийлөгчийн хоригтой холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Сандаг-Очир гишүүнээр тасаллаа. Энхбаяр гишүүний микрофоныг өгье.

Б.Энхбаяр: Хоригийг хүлээж авна. Ер Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийн 2 дахь үндэслэл нь Төсвийн хуулийг дагалдуулж гаргасан энэ тогтоол баталсан өдрөөсөө дагаж мөрдсүгэй гээд Монгол Улсын Ерөнхийлөгчид хууль, тогтоолын, баталсан хууль, тогтоолыг ажлын 3 хоногт хянаж, хориг тавих тэр боломжийг бас хангах Үндсэн хуулийн зохицуулалттай. Тэрийг нь хангалгүй шууд үйлчлүүлээд явчихсан юм байна. Хууль тогтоогчийн бас алдаа болсон байна. Тэгээд энэ асуудлаар бас урьд нь бас өнгөрсөн оны намар шиг санаад байх юм би бас нэг ийм асуудал гараад тэгээд Ерөнхийлөгчийн хориг тавих боломжийг хаачихсан байна гээд бас хориг тавигдаад Хууль зүйн байнгын хороо хүлээж авч байсан санагдаж байна. Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт ч гэсэн гарч байсан санагдаж байна. Тийм, Ерөнхийлөгчийн Үндсэн хуульд заасан хориг тавих эрхийг хууль тогтоогч хязгаарласан байна гэж.

Тэгэхээр ийм Цэцийн дүгнэлт урьд нь бас ийм асуудал гарч байхад бас яагаад манай Их Хурлыг Үндсэн хууль зөрчихөөс сэргийлүүлж байх, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч байх ёстой газар нь Улсын Их Хурлын Тамгын газар байгаа. Миний ойлгож байгаагаар Тамгын газар байр савандаа багтахгүй болоод орон тоо нь хэд ч болчихсон юм бүү мэд. Аймаар л юм сонсогдоод байгаа шүү дээ. Тэгээд яагаад энэ ажлаа хийхгүй байна? Энэ чинь Тамгын газраас асуулт асууж болох уу, үгүй юү? 2025 оны 7 сарын 09 гээд наадмын өдөр баахан хуулиуд машинддаг 40, 50 хууль машиндсан шүү дээ. Тэр өдөр л болсон асуудал байна. Энэ тэр машиндсан 40, 50 хуулиуд бүгдээрээ ийм алдаатай юм биш биз дээ арай? Тэр дотор жишээлбэл миний санаж байгаагаар одоо энэ төсвийг хэлэлцэж байгаа 5 үе шаттай болгосон дэгийн хуулийг гишүүдийн гар дээр хуулийн төсөл нь тараагдаагүй байхад Улсын Их Хурал хэлэлцсэн шүү. Төсвийн хуулийн, Их Хурлын чуулганы дэгийн хууль хэлэлцээд байсан. Би туслахаасаа энэ төсөл нь хаана байна гээд байсан. Тараагдаагүй байсан байхгүй юу. Тэгээд ингээд 2 өдрийн дотор тэр хуулийг баталсан. Одоо бид нарын баталж байгаа, өнөөдөр хэлэлцэж байгаа, төсвийг хэлэлцэж байгаа тэр Их Хурлын дэг арай батлагдсан өдрөөсөө дагаж мөрдөнө гэсэн заалттай баталчихсан юм биш биз дээ? Өөрөөр хэлбэл, Ерөнхийлөгчийн тэр хориг тавих 3 хоногийг бас зөрчихсөн Үндсэн хуулийн зөрчилтэй дэгийн хуулийн дагуу одоо бид явж байгаа юм биш биз дээ гэсэн асуулт байна.

Д.Цогтбаатар: Тамгын газраас удирдлага дуудах уу? Энхбаяр гишүүн ээ эндээ хэдүүлээ бас тодотголоо хийхгүй бол энэ чинь Төсвийн байнгын хороогоор хэлэлцсэн асуудал байгаа байх. Манайхаар бол хориг тавигдаж байгаа учраас ороод ирж байгаа болохоос биш анхлан хэлэлцэхдээ манай Хууль зүйн байнгын хороогоор ороогүй. Одоо хоригийн хувьд манайхаар хэдүүлээ орж ирээд хэлэлцэж байна шүү дээ. Энхбаяр гишүүний микрофоныг өгье.

Б.Энхбаяр: Одоо бол хариулах Улсын Их Хурлын Тамгын газрын удирдлагууд байхгүй байгаа юм байна. Тэгэхээр энэ асуудал маргааш Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэгдэх үед Тамгын газар надад 2025 оны 7 сарын 09-ний өдөр батлагдсан хэчнээн хуулийн дагаж мөрдөх хугацааг батлагдсан өдрөөс нь дагаж мөрдөнө гэж заасан бэ гэдэг лавлагааг гаргаж өгөөрэй. Хэрвээ тэр өдөр машиндсан бүх хуулиудын, хуулиуд ийм тухайн өдрөөсөө дагаж мөрдөнө гэсэн ийм алдаатай гарсан бол тэр хуулиудын эрх зүйн чадамжийн асуудал Үндсэн хуулийн түвшинд үүсэх нь байна шүү гэдгийг би протоколд тэмдэглүүлж байна.

Д.Цогтбаатар: Манайхан бас энэ Улсын Их Хурлын Тамгын газар руу хандаад маргааш гэхэд энэ хариуг Энхбаяр гишүүнд гаргаж өгөх ёстой шүү гэдгийг нь сануулж хэлээрэй.

Уянгахишиг гишүүний микрофоныг өгье.

Г.Уянгахишиг: 2 асуулт байна. Нэгдүгээрт сая ярьсанчлан энэ дагаж мөрдөх хугацаан дээр 1 асуулт байгаад байна. Одоо энэ тогтоол маань өөрөө Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж оруулж ирсэн төсөл байгаад байгаа Их Хурлын тогтоолын. Тэгэнгүүт энэ энэ тогтоолыг Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй гээд яг дагаж, дагуулж оруулж ирсэн хуулийнхаа л хүчин төгөлдөр болох хугацааг дурдчихсан байгаад байгаа юм.

Тэгэхээр энийгээ жишээлбэл, ер нь Ерөнхийлөгчийн хориг тавигдсан тохиолдолд тухайн заалтын хэрэгжих хугацаа чинь угаасаа л түдгэлзээд л явна шүү дээ. Зогсож л таарна. Тэрийг хүчин төгөлдөр болох нь. Тэгэхээр тэрийг жишээлбэл тусдаа хугацаа тавих ёстой байсан гэдэг нь ямар байдлаар томъёологдох ёстой байсан гэж хараад байгаа юм буюу Төсвийн хууль нь хүчин төгөлдөр болох нь нэг өөр өдөр байж байдаг тэгэнгүүт тогтоолынхоо хүчин төгөлдөр мөрдөх хугацааг хугацааг тэр Төсвийн хууль хүчин төгөлдөр болсноос хойш дахиад хэдэн хоногийн гэж юм уу, тэгээд ингэж тавих юм уу? Энэ өөрөө практик дээр яаж явах нь аягүй ойлгомжгүй болоод байна.

Хоёр дахь асуудал нь Ерөнхийлөгчийн хоригийн 1 дүгээр зүйлтэй холбоотойгоор Их Хурлын тогтоолоор Их Хурлын тогтоолд өөрчлөлт оруулах заалтыг оруулсан. Өөрөөр хэлэх юм бол Их Хурлын 46, 47 дугаар тогтоол бол тусгай хамгаалалттай газрын хил хязгаарыг тогтоосон буюу хуульд хэрэв тэр 47, 46, 47 дээр өөрчлөлт орууллаа гэхэд хуулиа зөрчсөн байдлаар оруулчих юм бол тэр Улсын Их Хурлын тогтоол тэртээ тэргүй хүчингүй болно. Хэрвээ тэр Улсын Их Хурлын тогтоол гаргаж, тусгай хамгаалалттай хил, газрын хил хязгаарыг тогтоохдоо хуульд зааснаас өргөн хэмжээгээр тогтоочихсон байвал тэрийг өөрчлөх боломж нь бас байгаа гэсэн үг. Тэгэхээр энэ агуулгаараа тэр 46, 47-г өөрчилнө өө гэдэг нь хуулийг өөрчил гэсэн заалт биш байхгүй юу. Тэр хуулийн

шаардлага бол хэвээрээ байгаа. Тэгэхээр хуульдаа нийцүүлээд 46, 47-гийнхоо тогтоосон хил хязгаарыг өөрчлөх боломжийг судлаач ээ гэдэг агуулга л харагдаад байгаа.

Тэгэхээр энийг ямар байдлаар өөрөөр ойлгож байна вэ? Дээрээс нь энэ 85 дугаар тогтоолын дагуу 46, 47 дугаар тогтоолд өөрчлөлт орууллаа гэхэд тэр өөрчлөлтүүд нь эхнээсээ хууль зөрчсөн асуудал үүсэж байгаа юу? Өөрөөр хэлбэл яг энэ Ерөнхийлөгчийн хориг дээр дурдсан үндэслэлүүд бол үндэслэлүүдээр тусгай хэрэгцээт газар, тусгай хамгаалалттай газар энийг тогтоох бол өөрөө бүгд хуулийн дагуу явж байгаа, хуулийн үндэслэлтэй явж байгаа.

Тэгэхээр тэр хуулиудыг зөрчсөн байдлаар тогтоол гаргаарай гэдэг юм бол Алт-3 хөтөлбөрийн 85 дугаар тогтоол дээр ерөөсөө дурдагдаагүй байхгүй юу. Тэгэхээр миний асуух гээд байгаа юм бол нэгэнт хуульд нийцэж байгаа тохиолдолд 46, 47-д байгаа тэр.../минут дуусав./

Д.Цогтбаатар: Гүйцээгээд микрофон өгье Уянгахишиг гишүүнд.

Г.Уянгахишиг: Нэгэнт хууль зөрчөөгүй тохиолдолд Улсын Их Хурлын 46, 47 дугаар тогтоолоор тогтоосон тэр хил хязгаарыг Их Хурлын тогтоолоор өөрчлөхөд асуудал байгаа юу? Өөрөөр хэлбэл, хууль зөрчөөгүй бол гэж асуугаад байгаа гэсэн үг. Тэгээд нөгөө дагаж мөрдөх дээр хоригийг, хугацааг оруулахын тулд жишээлбэл Төсвийн хуулийнхаа хүчин төгөлдөр мөрдөх хугацаанаас яаж салгаж оруулах байсан юм бэ гэдэг ийм 2 асуулт байгаад байна.

Д.Цогтбаатар: Ажлын хэсгээс хэн хариулах вэ? Үйлстөгөлдөр дарга 5 дугаар микрофон.

А.Үйлстөгөлдөр: Уянгахишиг гишүүнээс асуултад хариулъя. Энэ 85 дугаар тогтоолын 5 дугаар дэд заалтад болохоор энэ зарим газар нутгийн улсын тусгай хамгаалалтад авах хилийн заагт өөрчлөлт оруулах тухай 2020 оны 46, 47 дугаар тогтоол гээд байгаа шүү дээ. Үүний холбогдох хавсралтад өөрчлөлт оруулах тогтоолын төслийг боловсруулж Их Хуралд яаралтай өргөн мэдүүл ээ гээд заачихсан байгаа байхгүй юу.

Тэгэхээр өөрчлөлт оруулах гэж заасан байгаа нь хууль зүйн нэр томъёоныхоо ойлголтоороо ч гэсэн хавсралтад багтсан тэр газруудаас тодорхой хэсгийг тусгай хамгаалалтаас нь гаргах гэсэн шууд санааг агуулж байна гэж ойлгож байгаа юм. Ингээд заачихсан байгаа байхгүй юу. Өөрчлөлт оруулах, холбогдох хавсралтад 46 дугаар тогтоол чинь өөрөө ямар ямар газар нутгийг тусгай хамгаалалтад авч байгааг бүр тодорхой заачихсан байгаа. 47 чинь нөгөө Ноён уул. Тэгэхээр чинь энэ Ноён уултай, мөн Гутайн даваа, Монголын үзэсгэлэнт байгалиуд бүгд орсон тэр төрийн тусгай хамгаалалттай газар байгаа. Дээрээс нь тусгай хамгаалалттай дархан цаазтай газар, тэгээд төрийн тахилгатай 3 хайрхан дайрчихсан асуудал байгаа. Ой, усны асуудал, ой савын асуудлууд хүртэл орж орж байгаа.

Тэгэхээр энэ дээр холбогдох хавсралтад өөрчлөлт оруулах тогтоолыг яаралтай оруулж ир гэж байгаа байхгүй юу. Тэгээд энэ чинь болохоор шууд санаа агуулж байна шүү дээ. Шууд санаа. Тэгэхээр энэ дээр Монгол Улсын Ерөнхийлөгч

тодорхой байр суурь илэрхийлж байгаа юм. Тэгэхгүй ээ, энэ чинь ерөөсөө энэ одоо бид нарын нөгөө 2050-Алсын хараа урт хугацааны бодлогын баримт бичиг дээр хүртэл бүгд дээр тусгачихсан байгаа шүү дээ. 2030 он гэхэд тусгай хамгаалалттай газар нутгийг 30 хувьд хүргэх гээд. Одоо бидний байгаа нөхцөл байдал болохоор 21-тэй байгаа. Ингээд олон улс дээр хүртэл энийгээ зарлачихсан байж байдаг. Дээрээс нь үндсэндээ бол гол санаа бид нар энэ алтыг эргэлтэд оруулах зөндөө олон боломж байна. Үндсэндээ одоо 80 гаруй ордууд байгаа шүү дээ. Тэрний чинь ерөөсөө 14 нь л ашиглалтад ашигласан байгаа. Энэ алтны үндсэн ордууд байна шүү дээ. Тэрний чинь 68 нь эдийн засгийн эргэлтэд хүртэл ороогүй байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ 68-ыгаа эдийн засгийн эргэлтэд оруулах бүрэн боломжтой.

Жишээ нь 347 тонн алтны нийт нөөц байна гэсэн мэдээлэл байна. Тэгэхэд 68 үндсэн ордоо хэрвээ ашиглах юм бол 230 тонн алтны нөөц эргэлтэд орох боломж байхад оруулж чадахгүй байна л гэсэн асуудал байгаа. Тэгэхээр бид бүхэн одоо байгаа боломж нөөцөө ашиглая, үүцээ уудлаад тэр авдар саваа задлаад яах вэ энэ чинь ямар дайн байлдаан болоод, эсвэл улс орон бүр ингээд сүйрчихсэн асуудал байгаа биш. Тусгай хамгаалалтын газар нутаг руугаа орж яах гээд байгаа юм бэ гэсэн энийг болохгүй ээ энэ дээр хориг тавина л гэсэн асуудал байгаа шүү.

Бусад зүйл дээр нь хүлээн зөвшөөрч байгаа. Алтыг эргэлтэд оруулах бусад асуудлуудаа дэмжиж байгаа асуудал байгаа. Тэгэхээр энийг та бас тэр нөгөө шууд өөрчлөлт оруулах гэсэн санаа агуулж байгаа юм гэдгийг нь бас ойлгоорой. Түрүүн тэр Их Хурлын Тамгын газрын бас тодорхой хэмжээний бас алдаа байсан байж болзошгүй ээ гэж бас бид нар харж байгаа шүү. Тэр Энхбаяр гишүүн бас хэлж байна. Нэлээдгүй бас ийм зүйл гарчихсан байж магадгүй ээ гэж.

Тэгэхээр бид бүхэн энийг бол аливаа цаашид учирч болзошгүй зүйлээс сэргийлж бас энийг алдааг засах үүднээс нь бас энийг хориг тавьж байгаа гэж ойлгоорой. Тэгээд энэ дээр ялт ч үгүй 7 сарын 09-ний өдөр тогтоолын хүчин төгөлдөр болох хугацааг тогтоосон байгаа байхгүй юу. Тэр Төсвийн тухай хуульд өөрчлөх тухай оруулах тухай хууль. Тэгтэл төсөв батлагдсан өдөр нь өөрөө 7 сарын 09. Тэгэхээр таны асууснаар миний бодлоор энэ дээр Их Хурлын Тамгын газар илүү яаж томьёолохоо бас оруулж ирж, яаж томьёолох саналаа бас гаргах нь зүйтэй болов уу л гэж бодож байна. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Уянгахишиг гишүүний микрофоныг өгье тодруулъя.

Г.Уянгахишиг: Ерөнхийдөө бол ойлгоод байгаа юм. Тэгэхээр миний хэлээд байгаа санаа болохоор энэ дагаж мөрдөх хугацааны хувьд Төсвийн хуулиа дагаж мөрдөх хугацаан дээрээ алдаа гаргасан бол тэнд нь хориг тавих ёстой байсан юм биш үү. Тэр Төсвийн хуулийн чинь дагаж орж ирсэн тогтоолын дагаж мөрдөх хугацаан дээр хориг тавьчихаар тэр Төсвийн хуулийн чинь дагаж мөрдөх хугацаа нь яаж байгаа юм бэ гэдэг ийм асуулт яваад байгаа байхгүй юу. Нөгөө дагаж орж ирсэн, хууль дагаж орж ирсэн тогтоол шүү дээ. Энэ чинь бие даасан тогтоол биш.

Нөгөө 1 дүгээр зүйлийн хувьд болохоороо тэр жагсаалтад байгаа тусгай хамгаалалттай газруудыг ойлгож байна. Тэр тусгай хамгаалалттай газруудыг эхнээс нь жишээлбэл заагт нь өөрчлөлт оруулсан тохиолдолд Их Хурлын тогтоол

гарна шүү дээ. Тэгэхээр тэр Их Хурлын тогтоолд нь хориг тавьж болдоггүй юм уу? Өөрөөр хэлбэл, тэр чинь ганцхан газрын тухай асуудал биш, олон газрууд байгаа. Тэр олон газруудыг нь жишээлбэл Ноён уулынх ч гэдэг юм уу үнэхээр тусгай хамгаалалтаас гаргаж болохгүй газруудыг гаргачих юм бол тэр үед жинхэнэ хориг тавих ёстой юм биш үү?

Д.Цогтбаатар: Гүйцээгээд асуу асуу Уянгахишиг гишүүний микрофоныг.

Г.Уянгахишиг: Тэрнээс биш ерөнхийлөн бүгдийнх нь хил хязгаарыг магадгүй, магадгүй тийм ээ хуульд нийцүүлээд хил хязгаарыг арай явцууруулах боломж ч юм уу байж магадгүй шүү дээ. Тэр олон газруудын аль нэг хэсэгт нь яг энэ Алт хөтөлбөртэйгөө нийцүүлээд. Тэр нийцүүлээд гаргаж ирж байгаа хил хязгаарыг нь өөрчилж байгаа тэр Их Хурлын тогтоол хүчин төгөлдөр үйлчлэх үү, үгүй юү гэдэг чинь тусдаа асуудал. Тэгэхээр тэр үед нь хориг тавиад явж болохгүй байсан юм болов уу? Ингэж заавал бүхэлд нь хориг тавих хэрэг байсан уу л гэдэг санаа.

Д.Цогтбаатар: 5 дугаар микрофон өгье.

А.Үйлстөгөлдөр: Уянгахишиг гишүүний асуултад хариулъя. Нэгдүгээрт бүхэлд нь ерөөсөө хориг тавиагүй байгаа. Хэсэгчилсэн хориг тавьсан байгаа шүү дээ. Би энийг хэлчихье юун дээр бид нар бол буруу жишиг тогтох вий гэж их болгоомжилж байгаа юм. Өөрөөр хэлэх юм бол Их Хурлаас ингээд тогтоогоод өгчихдөг тэгээд энэ тогтоож байгаа хүн нь болохоор Засгийн газар руугаа эргээд чихчихдэг. Тэгэхээр энэ анхнаасаа бид нар бас ийм буруу жишиг дараа нь эдийн засгийн асуудалтай тулгарах аливаа зүйлүүд гарч ирэхэд ингээд бас тогтоол гаргаад Засгийн газар руугаа бас оруулаад байх буруу жишиг тогтчих вий гэсэн бас болгоомж бас байсан шүү гэдгийг бас хэлэх гэсэн юм.

Д.Цогтбаатар: 6 дугаар микрофон өгье.

Г.Ганболд: Уянгахишиг гишүүний асуултад хариулъя. Монгол Улсын Ерөнхийлөгч Алт-3 аяныг Засгийн газраас оруулж ирсэн тогтоолын хүрээнд бүрэн дэмжиж байгаа. Засгийн газраас оруулж ирсэн тогтоолын хүрээнд. Засгийн газраас оруулж ирсэн тогтоолд Их Хурлын ажлын хэсэг 5 дугаар заалт дээр бол эрс өөрчлөлт оруулсан. Засгийн газрын тогтоол дээр бол ерөөсөө тусгай хамгаалалттай газар нутгийг хөндөөгүй байсан. Гэсэн хэдий боловч яг таны асуугаад байгаа судалж оруулж ир гэсэн ерөөсөө үг хэллэг байхгүй ээ, судлаад оруулж ир гээгүй. 46, 47 дугаар тогтоолын тодорхой лицензтэй талбайнуудыг шууд яаралтай горимоор оруулж ирээд ингээд чөлөөлөөд энэ Алт-3 аяныг үргэлжлүүл ээ л гэсэн ийм тодорхой заалт байгаа юм.

Тийм учраас энэ нь Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулиар Их Хурлын бүрэн эрх бол ерөөсөө Засгийн газрын өргөн мэдүүлсэн тохиолдолд Тусгай хамгаалалттай газар нутгийн хилийн цэсийг тэлэх, хумих асуудлыг бол Засгийн газрын өргөн мэдүүлснээр л хэлэлцэх ёстой. Энэ агуулгаараа бол Засгийн газар өргөн бариагүй асуудлыг хэлэлцээд явсан нь хууль зөрчсөн л гэж үзэж ерөөсөө энэ заалт дээр хориг тавьж байгаа юм. Энэ нь саяын Үйлстөгөлдөр даргын хэлсэн богино хэмжээний эдийн засгийн хүндрэл, тодорхой хүндрэлийг далимдуулаад цаашдаа Их Хурлаас ингээд, Их Хурал санаачлаад тусгай

хамгаалалттай газар нутаг дархан цаазтай газруудаасаа газар чөлөөлөөд энэ ашигт малтмал олборлох ийм боломж, үүд хаалгыг нээх ийм эрсдэлтэй гэж үзээд л нэг ёсондоо таны хэлж байгаа Их Хурал дээр бүүр оруулж ирээд, дахиад яаралтай горимоор оруулж ирээд бүүр координатаар нь батлахаас нь өмнө урьдчилан сэргийлж хориг тавьж байгаа арга хэмжээ гэж та ойлгож болно.

Д.Цогтбаатар: Тийм танд 3 өглөө шүү дээ. Алтангэрэл гишүүн.

О.Алтангэрэл: Энэ ерөнхий хоригийн агуулгатай бол маргах хүн байхгүй байх. Тэгээд энэ Хүннүгийн үеийн гол дурсгал, манай эцэг дээдсийн алтан шарил байдаг энэ Ноён уулын холбоотой ч юм уу, Гутаан даваатай холбоотой ч юм уу ухууль гэх хүн байхгүй байх. Тэгэхдээ хууль зүйн хувьд энэ дээр гарцаа байхгүй сая Уянгахишиг гишүүний хөндөж байгаа асуудал яригдана. Өөрөөр хэлбэл, 46, 47 дугаар тогтоолуудад өөрчлөлт оруулах гээд байна гэж урьдчилж ингэж хориг тавьж хууль зүйн хувьд болох уу? Өөрөөр хэлбэл, шийдвэр гаргах, хууль тогтоох бол Улсын Их Хурлын өөрийнх нь онцгой бүрэн эрх. Хууль, Улсын Их Хурлын тогтоол Улсын Их Хурал өөрөө гаргах бүрэн эрхтэй. Тэгээд агуулгыг ойлгож байна. Энийг ингээд хасах гээд байна, алт ухах гээд байна гэдэг агуулгаар орчихсон гэдгийг нь ойлгож байна.

Тэгэхдээ цаашид эдгээр тогтоолууд дээр өөрчлөлт оруулах магадгүй энэ тогтоолууд дээр дурдагдсан солбицлуудыг өргөсгөөд энэ тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг өргөсгөө гэхлээр энд өөрчлөлт оруулах гэж байгаа зүйл дээр нь хориг тавьж байсан юм, энийг хөндөж болдоггүй юм гэдэг ийм жишиг үүсэх үү? Хууль зүйн хувьд, хууль зүйн хувьд эдгээр тогтоолууд дээр өөрчлөлт оруулах гэдэг асуудал дээр хориг тавьж байгаа нь түрүүний Уянгахишиг гишүүний асуултад гарч байгаа байхгүй юу. Үнэхээр өөрчилчихвөл энэ дээр асуудал гарна. Хориг тавивал хүлээж авах, бүх ярилцах юм гарна. Урьдчилж ингэж хориг тавьж байгаа нь ер нь энэ хууль зүйн хувьд ер нь үндэслэл нь юу юм бэ, зөв юм уу гэдэг эхний асуулт.

Хоёр дахь асуулт. Энэ чухал асуудал ярьж байхад Алт-3 хөтөлбөр энэ чухал асуудал ярьж байхад бид нар энэ Засгийн газраас хариуцсан тэр Эрдэс баялгийн сайдыг нь оруулмаар байна. Ямар үүднээс энийг ер нь ярьж байсан юм, ямар ач холбогдолтой гэж үзсэн юм. Одоо чинь тэр хөрөнгө оруулалтыг хамгаална энэ тэр гээд ярьж байгаа шүү дээ. Тэгээд энд нь ямар хэмжээний харилцаа хөндөгдөх юм? Үнэхээр нөлөөтэй юм уу, эдийн засгийн үр дагавар байгаа юм уу, Эрдэс баялгийн яам ямар бодолтой байгаа юм? Энэ дээр ер нь өөрийн гэсэн бодлого байгаа юм уу, үгүй юу гэж ингэж бас Уул уурхайн сайдаас асуумаар л байна Эрдэс баялгийн сайдаас. Ийм асуултууд байна. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Хэддүгээр микрофон өгөх вэ? Ажлын хэсэг 5 дугаар микрофон.

А.Үйлстөгөлдөр: Алтангэрэл гишүүнд баярлалаа. Энэ би түрүүнийхээ зүйлийг л давтах гээд байна л даа. Ерөнхийлөгчийн байр суурь бол аливаа эдийн засгийн хүндрэлтэй аливаа асуудлуудаас болоод тусгай хамгаалалттай газрууд руугаа ялангуяа энэ бид бүхний өвийг тээж байгаа энэ газрууд руу ингэж ордог ийм жишиг энэ тогтоолоос хойш ингээд гарчих вий дээ нэгэнт Их Хурлын тогтоол учраас Засгийн газар заавал хэрэгжүүлэх үүрэгтэй. Тэгээд Засгийн газар

хэрэгжүүлэхдээ тогтоолд оруулсан тэр 5 дугаар дэд заалтын дагуу энийг чинь яаралтай горимоор өөрчлөлт оруулахаар оруулж ирэх нь байна шүү дээ. Тэгэхээр энэ бол буруу жишиг байж байна. Тэгээд Ерөнхийлөгчийн өөрийнх нь бүрэн эрх, хориг тавих бүрэн эрх байгаа. Ийм л тайлбар байна даа.

Д.Цогтбаатар: 6 дугаар микрофон өгье.

Г.Ганболд: Тийм Ерөнхийлөгч хориг тавихдаа яг тийм таамгаар ч юм уу оруулж ирээгүй зүйлд нь яг тавьсан гэж бас ойлгоход хэцүү. Хэлэлцүүлгийн явцад Байнгын хороо, чуулган дээр бол олон гишүүд эсэргүүцэж байсан. Тэр хүрээнд яг Алтангэрэл гишүүний асууж байгаа шиг тухайн үед салбарын сайд нь тов тодорхой 3 лиценз ярьчихсан юм. Цагаан баавгайт, Гацуурт, Гутайн даваа 3-ыг л үйлдвэр барьчихсан 3 үндсэн ордын уурхай байгаа учраас энэ 3-ыг л чөлөөлөх гэж байгаа юм. Энэ 3-ыг чөлөөлж ингээд эдийн засгийн эргэлтэд оруулах гэж байгаа юм гэдгээ тов тодорхой ярьж байсан учраас энийг бид нар таамгаар гэж үзэхгүй яг ийм зүйлүүд оруулж ирж байгаа юм байна гэдэг нь тов тодорхой байсан учраас одоо таны хэлээд байгаа урьдчилаад оруулж ирээгүй байхад нь яагаад тавиад байгаа юм гэдгийг бас агуулгаас хараад өөр агуулгаар ер нь ийм 3 лиценз хөндөж байгаа юм байна. Ийм 3 үндсэн орд хөндөж байгаа юм байна. Тэгэхээр энэ 46, 47 дугаар тогтоолыг авахад Ноён уул бол дархан цаазтай газар, Хүннүгийн үеийн булш бунхан, эртний түүхийн дурсгалт, хосгүй байгалийн үзэсгэлэнт газар гэж байгаад авч байсан. 47 дээр нь Гутайн даваа бол байгалийн хосгүй үзэсгэлэнтэй ийм газар гэж байгаад авч байсан ийм газрууд хөндөгдөх нь ээ гэдгийг тухайн үед Их Хурлын гишүүд, мөн нутгийн иргэд, төрийн бус байгууллагуудаас Ерөнхийлөгчид бол тухайн үед нь хандаж байсан учраас судалж хориг тавихад хүрсэн гэдгийг хэлье.

Д.Цогтбаатар: Сандаг-Очир гишүүний микрофоныг өгье.

Ц.Сандаг-Очир: Ерөнхийлөгчийн хоригийн агуулгыг ойлгож байгаа. Гэхдээ бас асуудал байна. Үндэслэн Улсын Их Хурлын 46, 47 дугаар 20 оны тогтоолыг тогтоолоор, Улсын Их Хурлын тогтоолоор энэ тусгай хамгаалалттай газар нутгийг авсан. Ингээд энэ хилийн цэсийг өөрчилж байгаад алт ухах гэж байна гэж. Мэдээж олон улсын конвенцод нэгдэн орсон байдлаар манайх 2030 он гэхэд нийт газар нутгийнхаа 30 хувийг, 50 он гэхэд 35 хувийг тусгай хамгаалалттай газар нутагт авах ийм гэрээ, конвенцтой энэ хүрээндээ хийж байгаа гэж ойлгож байгаа.

Гэтэл 47 дугаар, 20 оны 47 дугаар Улсын Их Хурлын тогтоол чинь ялт ч үгүй Ноён уулыг ганцхан улсын тусгай хамгаалалттай газарт авсан. Хавсралтаараа яг уртраг, өргөөрөө координатыг нь яг ийм байдлаар гээд ингээд маш тодорхой зааж өгөөд ингээд баталсан тогтоол юм байна лээ. Гэтэл 46 дугаар тогтоол чинь, 20 оны 46 тогтоол чинь хэрэгжээгүй байгаа шүү. 9-н газрыг улсын тусгай хамгаалалттай газар нутгийн байршилд авсугай. Харин хилийн заагийг нь тогтоохыг тухайн үеийн Засгийн газарт даалгасугай гэсэн байсан. Гэтэл өнөөдрийг хүртэл 20 оноос хойш өнөөдөр 5 жилийн хугацаанд энэ хилийн цэсийн энэ 9 газрын 46 дугаар тогтоолоор тогтоосон тусгай хамгаалалттай газар нутаг авсан гэх энэ 9 газрын уртраг, өргөрөг хилийн заагийг огт тогтоогоогүй байгаа. Огт тогтоогоогүй байгаа. Засгийн газар үндсэндээ ажлаа хийгээгүй гэсэн үг. Гэтэл ийм хэрэгжээгүй ажил нь хийгдээгүй. Энийг би бас Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас судалж гаргуулж авсан. Тэгээд огт хэрэгжээгүй, хэрэгжээгүй, хэрэгжээгүй.

Ямар учир шалтгаанаар хэрэгжээгүй нь бас учир шалтгаан бас байх шиг байгаа юм. 120 гаруй нэгж талбар иргэдийн давхцалд үүсчихсэн. Тэдгээрт давхацчихсан газрынх нь нөхөн олговорт нь мөнгө олгох ёстой, энэ мөнгө олгох нөхөн олговрын асуудал нь шийдэгдээгүй.

Тийм учраас энэ 46 дугаар тогтоолоор тусгай хамгаалалттай газар нутгийг авсан энэ 9 газар байршлуудыг хилийн цэсийг тогтоох боломжгүй байна гэсэн ийм маягтай, агуулгатай ийм Хэрэг эрхлэх газраас ийм танилцуулга, мэдээллийг өгсөн байгаа. Тэгэхээр энэ хэрэгжээгүй энэ 46 дугаар тогтоолыг үндэслээд 85 дугаар, 25-ын 85 дугаар тогтоол гарчихсан. Тэгэхээр энэ 85 дугаар тогтоол чинь яаж хэрэгжих юм. Хилийн заагийг нь тогтоогоогүй байхад тэр газар нутгийг алийг ямар цэсийн хүрээнд, ямар хил хязгаарын хүрээнд тусгай хамгаалалттай газар гэж үзэх юм? Энэ нь тодорхойгүй байна. Энийг үндэслээд 85 дугаар тогтоол Улсын Их Хурал гаргачихсан сая 7 сард. Энийг үндэслээд хориг тавигдаж байна. Тэгэхээр ерөөсөө энэ хориг 85 дугаар тогтоолууд чинь өөр.../минут дуусав./

Д.Цогтбаатар: Сандаг-Очир гишүүний микрофоныг гүйцээгээд өгье.

Ц.Сандаг-Очир: Өөрсдөө хууль зүйн хувьд хүчин төгөлдөр хууль, эрх зүйн баримт бичиг мөн үү, үгүй юу гэдэг асуудал хөндөгдөж байгаа байхгүй юу. Хэрэгжихгүй яваад байна шүү дээ. Хэрэгжихгүй яваад байгаад байгаа тогтоолууд дээр тогтоол гараад тэр дээр нь Ерөнхийлөгчийн хориг орж ирж байна шүү дээ. Энийг чинь юу гэж үзэх юм? Энэ дээр та бүхэн Ерөнхийлөгчийн итгэмжилсэн төлөөлөгч нар энийг судалж үзсэн үү? Энэ Их Хурлын гаргасан тогтоолыг Засгийн газар яагаад хэрэгжүүлэхгүй байгаа юм? Энийг судалж үзсэн үү? Тэгээд энийг үндэслээд гаргасан 85 дугаар тогтоол хууль хүчин төгөлдөр мөн үү? Энийг үндэслэж гаргасан 87 дугаар тогтоол дээр тавигдаж байгаа Ерөнхийлөгчийн хориг чинь өөрөө бас хууль зүйн хувьд хэр үндэслэлтэй вэ гэдэг энэ асуудалд хариулт өгөөч.

Д.Цогтбаатар: 6 дугаар микрофон ажлын хэсэг. Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя.

Г.Ганболд: 47 дугаар, 46 дугаар тогтоолын 3 дээр 6 хавсралтаар таны хэлээд байгаа хилийн заагийг бол бүгдийг нь ингээд тогтоочихсон. Бүгдээрээ ингээд координаттайгаа бүгдээрээ байгаа. 1 дүгээр хавсралтаар Онон-Балжийн БЦГ-ын өргөтгөлийн хилийн заагийг 1 дүгээр, Ачит нуур, Дэвэлийн арлын юу гэнэ ээ, Дэвэлийн арлын БЦГ-ын хилийн заагийг 2 дугаар, Хомын талын БЦГ-ын 3 дугаар гээд 6 хавсралтаар координатаар авчихсан. Таны хэлээд байгаа 4 дүгээр хавсралт бол байгалийн тусгай хамгаалалтад авсныхаа дараа ангилал тогтоож байгаа юм. Дархан цаазат газар юм уу, байгалийн нөөц газар юм уу, дурсгалт газар юм уу гэдэг ангиллыг Засгийн газарт тогтоохыг л үүрэг болгосон. Засгийн газар тэр дээр бол яг Ноён уулан дээр дархан цаазат гээд авчихсан. Бусдууд дээр нь яах вэ ерөнхий тусгай хамгаалалтад авчихсан зүгээр яг дэглэмийнх нь ангиллыг тогтоогоогүй байгаа нь бол энэ таны хэлээд байгаа шиг тийм хууль зөрчих байдалд орохгүй.

Яагаад гэхээр тусгай хамгаалалтад бүхэлд нь авчихсан координатаараа бүр ингээд тоо хэмжээтэй нь авчихсан байгаа. Дэглэмийн тухайд бол Засгийн газар өөрсдөө байгалийн нөөц үү, цогцолборт газар уу гэдгийгээ ингээд тогтоогоод явах

ийм боломжтой. Тэгэхдээ энийг аваагүй байгаа нь энэ тогтоолоор тусгай хамгаалалтад авсан 46, 47 дугаар тогтоол бол хилийн заагаараа тусгай хамгаалалтад байгаа гэж ойлгож болно.

Д.Цогтбаатар: Сандаг-Очир гишүүний микрофоныг өгье тодруулъя.

Ц.Сандаг-Очир: Би энэ Хэрэг эрхлэх газраас энэ талаар бас хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар танилцуулга, мэдээлэл авсан юм л даа. 20 оны 5 сарын 07-ны 46 дугаар “Зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах хилийн заагт өөрчлөлт оруулах тухай” тогтоол, Байгалийн нөөц болон дурсгалт газрын ангиллаар улсын тусгай хамгаалалтад авч байгаа газар нутгийн хилийн заагийг тогтоохыг Монгол Улсын Засгийн газарт даалгасугай. Энэ хэрэгжээгүй ээ гээд ингэж байгаа юм. Тэгэхээр энэ хэрэгжээгүй байгаа учраас хилийн зааг нь тогтоогдоогүй байна өнөөдрийг хүртэл.

47-той ярих юм байхгүй. 47-г тухайн үед нь тогтоолтойгоо, хавсралттайгаа бүх координатыг нь уртраг, өргөргөөр нь ингээд батлаад төсөв, санхүү ашиглалтын өмнөх захиргаа дээр нь ингээд байгуулчихсан. Гагцхүү энэ 46 дээр ингэж хэрэгжээгүй байгаа юм байна лээ шүү. Энийг сайн судлаарай.

Д.Цогтбаатар: Би ажлын хэсгийн өмнөөс юу хариулах вэ гэхдээ Сандаг-Очир гишүүн ээ наад 46 дээр чинь ийм нюанс байгаа шүү. Нэгэнт Их Хурал гаргаад тэгээд Засгийн газар хэрэгжүүлээгүй байгаа бол Засгийн газрын асуудал. Түүнээс гаргачихсан тогтоол хүчин төгөлдөр байхгүй юу. Хэрэгжүүлээгүй байгаа бол Засгийн газартай хариуцлага тооцох асуудал болохоос биш хуулийн хүчин төгөлдөр байдал нь тогтоолынх хэвэндээ байгаа. Тийм учраас хориг тавьж болохуйц эрх зүйн акт хэвэндээ байгаад байгаа гэж би ойлгож байна. Тэгээд энэ дээр ажлын хэсэг сая өөрийнхөө байр суурийг бас хэлж байна.

Одоо ингээд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Ерөнхийлөгчийн хоригтой холбогдуулан байр сууриа илэрхийлж үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү.

Баярбаатар гишүүн. Байж байгаарай энэ чинь Сандаг-Очир гишүүнээр тасаллаа. Баярбаатар гишүүний микрофоныг өгье.

Б.Баярбаатар: Гишүүдийн хэлж байгаа энэ хууль зүйн үндэслэл тал талаас нь бас бодож үзэх нь зөв байх. Сандагаа гишүүн ч гэсэн бас энэ хавсралт нь зарим нь байна, байхгүй гээд зөрүүтэй юм яриад байгаа юм. Би зүгээр энэ саяхан болсон л зүйл учраас энэ дээр хэлье. Энэ тогтоолын төслийг чинь төсөв дагалдуулаад Засгийн газар өргөн барьсан юм. Тэгээд Их Хурал дээр энийг Даваагийн Цогтбаатар гишүүн байж байна бид нар ажлын хэсэг болсон тийм ээ? Энэ Ноён уулыг чинь ухах гээд байна энэ 2 заалтаа аваад хаячих гэсэн тухайн үед Засгийн газрын гишүүд нь ёстой тийм юм байхгүй, Их Хурал зүгээр л батлаад өгчих, наад тогтоолын чинь гол амин сүнс нь энэ байгаа юм л гээд байсан. Одоо энд ингээд л энэ чинь тодорхой л байгаа байхгүй юу. 47 дугаар тогтоолын хавсралтад гэхээр чинь энэ чинь 47 нь ганцхан Ноён уул л байж байгаа байхгүй юу.

Тэгээд 20 оны зүйлийг эргэн санаад ярихад тэр үед Ерөнхий сайд Хүрэлсүх дарга байсан энэ Гутаан даваа, Ноён уулыг энэ хэл ам дагуулаад байсан, олон удаа шүүхээр маргаан нь шийдэгдээд явж байсан энэ зүйлийг тусгай хамгаалалтад авлаа гээд бид нар чинь энэ олон нийтэд зарлаад тэгээд энийг чинь тусгай хамгаалалтад авсан авсан шүү дээ. Тэгээд Засгийн газрын гишүүдийнх нь хэлснээр ажлын хэсэг хүртэл байгуулж ажиллаад, Туваан гишүүн ахлаад, бид хэд ороод энэ заалтыг нь ингээд хасчихъя гээд байхад л яах юм бэ байж бай гэсээр байгаад л батлуулсан юм. Тэгээд Ерөнхийлөгчийн хоригийг хүлээж авах ёстой. Энэ Алт хөтөлбөрийг эрчимжүүлэх нь зөв байх. Тэгэхдээ энэ тусгай хамгаалалттай газар руугаа их өнөөдөртөө ороод хэрэггүй байх. Тэгээд энэний дараа дараадаа тэр хойч үе нь болдог юм байгаа биз. Заавал өнөөдөр энийг нөөц нь тогтоогдсон зүйл рүү ингээд тэгээд байж л байг тэр нь. Өшөө энэнээс чинь гадна зөндөө л олон ашиглах боломжтой ордууд байгаа юм байна лээ шүү дээ.

Ер нь энэ бичиг баримт, энэ хууль хяналт, тогтоолын асуудал дээрээ энэ ямар ч шатанд байсан гэсэн энэ хууль зүйн үнэлгээг ер нь хийдэг байх ёстой байх. Яг энэ ардаас нь ингээд энэ хавсралтууд нь гарсан юм уу? Гарсан бол хаа байна? Энэ нийцэж байгаа юм уу, нийцэхгүй байгаа юм уу? Энэ үг, өгүүлбэр, тасалбарынхаа асуудал дээр ч гэсэн. Тэгээд бүх зүйл ингээд дараа нь болчихсоны дараа ингээд тэр үед тэгчихсэн, ингэчихсэн, тэр нь өөрөө ингэлээ, энд халдлаа, тэглээ, ингэлээ гээд ингээд байхгүй хойгуур нь баталчихсан юм шиг бүгд л адилхан л байж байгаад л баталцгаасан шүү дээ.

Тэгэхээр эдгээр зүйлүүд дээрээ бас дараа дараадаа энэ Хууль зүйн байнгын хорооны ч бас чиг үүргийн хувьд энэ дээр нь бид нар ч бас зөвлөх л үүрэгтэй л байх бас. Ер нь зүгээр тийм нэр уснаасаа авхуулаад. Тэгэхээр эдгээр зүйлүүддээ дараад анхаарах нь зөв. Ерөнхийлөгчийн хоригийг дэмжиж байна. Энэ 2 заалт энэ Алт хөтөлбөрийн тогтоолын төсөл байж болно. Өнөөдөр өглөө хүртэл би Засгийн газрын гишүүдээс асуусан. Ингээд Ерөнхийлөгчийн хоригийг чинь хүлээгээд авна. Тэгээд энэ тогтоолын чинь төсөл ямар ч асуудал байхгүй л гэж байсан.

Тэгвэл тухайн үедээ тэгвэл энийг авхуулчихгүй яасан юм? Заавал асуудалгүй гэж оруулчихаад, оруулсан хойно нь хориг тавьчихангуут нь одоо тэгвэл авлаа шүү гээд, ав ав одоо наадах чинь ямар ч асуудал байхгүй гээд ингээд ойлгогдохгүй юм яриад байгаа байхгүй юу. Тэгээд сүүлд нь явж явж парламент буруутай юм шиг болчихсон. Тэгэхээр энийгээ бид нар бас тал талаас нь харах ёстой байх гэж бодож байна. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Ганбат гишүүний микрофоныг өгье.

Д.Ганбат: Ерөнхийлөгчийн хоригийг дэмжихгүй байна. Энэ чинь бас байгаа нөхцөл байдалдаа бас энэ улс орныхоо эдийн засаг, энэ юм хумаа бодох хэрэгтэй шүү дээ. Тийм. Засгийн газрыг ч гэсэн бас ойлгохгүй байна. Тийм. Засгийн газар ч гэсэн олигтой ажил хийхгүй л байх шиг байна шүү дээ. Энэ улс орон өнөөдөр хүүхдүүд ширээ, сандалдаа багтахгүй гурваараа сууж байна. Багш нарын цалин хэд байгаа билээ ийм байдалтай байна шүү дээ. Сая таван зуухан мянган төгрөгөөр багш нарыг яаж ажиллуулах юм, тэгээд энэ залуучуудын ямар болж байгааг бид нар харж байна шүү дээ. Тийм ийм байна. Ийм үед чинь дэлхийн зах зээл дээр хэзээ ч байгаагүй тийм үнэтэй байна шүү дээ алт 3650-тай байна уу?

Цаашдаа ч 4000 болно гэж байна. Бид энэ алтыг олборлоод энэ өндөр үнээр нь зараад тэрүүгээрээ байгаль орчноо сэргээх ёстой байхгүй юу. Технологи ч гэсэн сайжирчихсан. Маш өндөр технологийг тэн дээр оруулах хэрэгтэй. Заавал тэр хайрлаад, хамгаалаад байгаа юмаа хэсэгчлэн гэрээ хийгээд ингэж болно шүү дээ. Ингэж л ажиллах ёстой байтал тэгээд 1 попорч байгаа маягаар ч юм уу, иймэрхүү маягаар болохгүй ээ. Тийм би Ерөнхийлөгчийн олон юмыг дэмждэг.

Гэхдээ энэ дээр арай санал зөрж байна. Гишүүд ч гэсэн, Их Хурал ч гэсэн бас жоохон ухаалаг ажилламаар байна. Энэ Засгийн газар ч гэсэн мөнгө төгрөг байхгүй, болохгүй, бүтэхгүй байна гээд л. Энэ цаг хугацаа энэ хүүхдүүдийг чинь яаж сурах юм? Энэ багш нар чинь яагаад ийм цалинтай байгаа юм? Дээр нь авлига авна. Энэ бүх юм чинь нэгдэж явсаар байгаад энэ улс орныг чинь дуусгаж байна шүү дээ. Одоо тэр авлигачидтайгаа тэмцэх юм уу, тэмцэхгүй юм уу? Энэ Хууль зүйн байнгын хороон дээр ярихад тэр авлигажсан байшингууд чинь бүгдээрээ сүндэрлээд л босоод байна шүү дээ. Тэгээд намайг л Хууль зүйн байнгын хорооны дарга байх үед л 70 хэдтэй байлаа шүү дээ. Одоо тэр бид нар чинь Балбын ар талд, Непалын ар талд зогсож байна шүү дээ. Ийм нөхцөл байдалтай байхад бид нар бас хувийн хэвшлээ сайн ажиллуулаад, татах юм хумыг нь сайн аваад ингэх хэрэгтэй байна шүү дээ. Ингэж ажиллавал зүгээр байх. Энийг эргэж харах хэрэгтэй гэж бодож байдаг юм.

Д.Цогтбаатар: Сандаг-Очир гишүүний микрофоныг өгье.

Ц.Сандаг-Очир: Би асуусан асуулттай холбогдуулж үгээ хэлье. Ерөнхийлөгчийн хоригийн 47 дугаар тогтоолын Ноён уулын холбоотой газар нутгийг ухуулахгүй ээ гэдэг агуулгаар тавигдаж байгаа. Энийг дэмжиж байна. Өчнөөн юм болж байгаад энэ улсын тусгай хамгаалалттай газар нутагт авсан. Харин 20 оны 46 дугаар Улсын Их Хурлын тогтоол чинь өөрөө Засгийн газарт даалгасан хилийн заагийг тогтоох тухай ажлаа өнөөдрийг хүртэл хийгээгүй байгаа 5 жилийн хугацаанд. Тэгээд энэ тогтоолыг хэрэгжүүлээгүй байхад энийг үндэслээд 85 дугаар тогтоол гаргачихсан 25 онд. Энийг үндэслээд Ерөнхийлөгчийн хориг орж ирж байна.

Тэгэхээр Засгийн газрыг энэ ажлаа хурдан яаралтай хий гэдэг чиглэлээр харин Улсын Их Хурлаас бас үүрэг чиглэл өгмөөр байгаа юм. Бид нар газар нутгаа тусгай хамгаалалттай газар нутгийг авчихсан авчихсан гээд л яриад байдаг. Яг нидэр дээрээ хилийн заагийг нь тогтоох ажлыг огт хийгээгүй байна. Тэр газар нутгууд нь маш олон иргэн, аж ахуйн нэгжийн газруудтай давхацчихсан байна. Хүчингүй болгоно гэхээр иргэн, аж ахуйн нэгжүүдийн газрын нөхөн олговрын асуудал яригдана. Маш олон үе шаттай ажлууд хийгдэнэ. Энэнээс болоод өнөөдөр 5 жилийн хугацаанд үе үеийн 3 Засгийн газар ажлаа хийгээгүй байгаа.

Тэгэхээр тэр авсан гээд байгаа тусгай хамгаалалттай газар нутаг чинь хилийн зааг нь хаагуур байх гэдгийг мэдэхгүй байна шүү дээ бид нар. Авсан гээд байгаа нь. Засгийн газраас ирүүлсэн, Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн бичиг баримт дээр нь, танилцуулга дээр нь хэрэгжээгүй ээ гээд ингээд албан ёсны материал байна л даа. Хэрэгжээгүй. Бүр тэгж яривал 19 оны 5 сарын 02-ны өдрийн 41 дүгээр тогтоолоор хүртэл маш 20 орчим газрыг тусгай хамгаалалттай газар нутагт авсан хир нь хил заагийг нь өнөөдөр хүртэл тогтоогоогүй байгаа. Ингээд ерөөсөө Засгийн газар хийх ажлуудаа хийгээгүй явж ирж байгаа байхгүй юу. Тэгээд энэ Алт

хөтөлбөр ингээд гараад ирэнгүүт энэнтэй холбогдоод хилийн заагийн асуудал хөндөгдөөд ирж байна л даа.

Тэгэхээр энэ Засгийн газраар энэ хил заагийг нь тогтоолгох асуудлуудыг яаралтай оруулж ирж хийлгэх асуудлыг Улсын Их Хурлаас бас Засгийн газарт үүрэг чиглэл өгөхгүй бол энэ ажлууд хийгдэхгүй яваад байгаа юм байна лээ шүү. Тийм учраас би энэ Ерөнхийлөгчийн хоригийг нь 46 дугаар тогтоол дээр тавьсан гэдгийг нь хасчихвал болохгүй юм уу? 47-г нь бүрэн дэмжиж байна. Энэ газар нутаг, хилийн зааг нь бүрэн тогтоочихсон Ноён уулын холбоотой тогтоол байгаа 47 бол.

Д.Цогтбаатар: Гишүүд үг хэлж дууслаа.

Энэ дээр би өөрийнхөө байр суурийг хэлчихье гэж бодож байна. Энэ Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 25.2 дээр түрүүн энэ Ганболд зөвлөх яг тодорхой хэлчихнэ лээ. Яг бодитоор хуулийг чинь текст тэгж байгаа юм л даа Засгийн газрын өргөн мэдүүлснээр л гэж байгаа юм. Тэгээд хэрэв өргөн мэдүүлээгүй бол бид нар энэ энийг хэлэлцэх ч угаасаа тэр фактыг бид өөрчилж чадахгүй байхгүй юу.

Тэгэхлээр энэ чинь яах аргагүй хориг тавих үндэслэл өөрөө эрх зүйн тэр ард нь Ноён уул байна уу, байхгүй юу асуудал биш болчихож байна шүү дээ энэ чинь. Орох ёстой процедураараа ороогүй болохлоор энэ дээр хориг тавих үндэслэл чинь яг эрх зүйн хувьд өөрөө гараад ирж байгаа юм. Тэр үүднээс нь би энд хоригийг хүлээн авах нь зүйтэй гэж миний хувьд бодож байна.

Ингээд би өөрийнхөө байр суурийг хэллээ. Ингээд Ерөнхийлөгчийн хоригтой холбогдуулан гишүүд байр сууриа илэрхийлж, үг хэлж дууслаа.

Монгол Улсын Их Хурлын 2025 оны 85 дугаар тогтоолын 1 дэх заалтын 5 дахь дэд заалтад хэсэгчлэн тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хүлээж авах нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Гишүүд санал хураалтдаа бэлдээрэй. Санал хураалт шууд санал хураалт.

Минийх дээр гарсангүй. Би санал сая өгсөнгүй. Үгүй үгүй минийхэд Байнгын хорооны даргынх дээр гараагүй. Би саналаа өгөөгүй байхад чинь. Тийм тийм. Тэгэхлээр энд лав л миний юу ажилласангүй. Би өөрийнхөө байр суурийг тодорхой хэлсэн. Би дэмжинэ ээ гээд. Хэнийх бас Дэлгэрсайхан гишүүнийх ажиллаагүй байна.

Тэгэхлээр саяын санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтдаа дахин бэлтгэе. Хуруугаа хийх юм байна шүү манайхан.

Саяын би саяын санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

64.7 хувиар санал дэмжигдлээ.

Ганбат гишүүн ээ таных. Тэгвэл санал хураалтдаа бэлдье. Одоо ингээд санал хураалт.

76.5 хувиар санал дэмжигдлээ. Юу билээ? Тийм хоригийг хүлээж авъя гэж санал дэмжигдлээ 76.5 хувиар.

Номинчимэг гишүүн ээ ахиад 2 дахь санал байгаа юм.

Монгол Улсын Их Хурлын 2025 оны 85 дугаар тогтоолын 3 дахь заалтад хэсэгчлэн тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хүлээж авах нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Одоо энэ чинь бэлэн байгаа билүү манайхан? Санал хураалт явуулъя.

76.5 хувиар санал дэмжигдлээ.

Ингээд Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хэлэлцсэн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Баярбаатар гишүүн танилцуулчих уу? Баярбаатар гишүүн танилцуулна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн хуралдаан хаасныг мэдэгдье.

18.14 цаг

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

Д.ОТГОНДЭЛГЭР